

ЭНДҮҮРЭЛ

СҮНСНИЙ ЗААВАР, БАРЫН СҮНС, НЭГ
АЙМШИГТАЙ ЭЭЖ!



НЭГ ДҮГЭЭР БОТЬ
ОУЭН ЖОНС



ЭНДҮҮРЭЛ

Сүнсний Заавар, Барын Сүнс, Нэг Аймшигтай Ээж!

ОУЭН ЖОНС

Орчуулагч:

Сод Эрхэмбаяр

Copyright © 2021

Оуэн Жонс
ЭНДҮҮРЭЛ

5 дахь Хэвлэл

Хэвлэх үйлдвэр

Megan Publishing Services

<https://meganthemisconception.com>

Оуэн Жонсын энэхүү бүтээлийн зохиогч болох эрхийг 1988 оны Загвар Патентийн Зохиогчийн эрхийн тухай хуулийн 77, 78-р хэсэгт заасны дагуу баталгаажуулсан болно. Зохиогчийн ёс суртахууны эрх баталгаажсан.

Энэхүү уран зохиолын дүрүүд болон үйл явдлууд нь зохиолчийн уран сэтгэмж, төсөөлийн бүтээл юм.. Зарим газар орон нь байж болох ч үйл явдлууд нь бүрэн зохиомол юм.

Холбоо барих.:

<http://facebook.com/angunjones>

http://twitter.com/owen_author

owen@behind-the-smile.org

<http://owencerijones.com>

Доорх вэб хаягаар хандан э-мэйл хаягаа оруулж Оуэн Жонсын ном зохиолуудын мэдээлэл, товхимолыг хүлээн авахаар бүртгүүлж бидэнтэй нэгдээрэй

:

<http://meganthemisconception.com>

Тус цувралын бусад өгүүллэгүүд:

Меганы цувралууд

Сүнсний заавар, Барын Сүнс болон Аймар Ээж!

Эндүүрэл

Мегэны Арван Гурван Нас

Меганы Сургуулийн Аялал

Меганы Сургуулийн Шалгалт

Меганы Дагагчид

Меган ба Төөрсөн Муур

Меган ба Хотын Захирагч

Меганы Царай Егөөдөл

Меганы Өвөө Эмээгийн Айлчлал

Меганы Аавын Өвдөлт III

Меган Амралтанд Явав
Меран ба Хулгайч
Меган ба Дугуйчин
Меган ба Хөгшин Хатагтай
Меганы Цэцэрлэгт Хүрээлэн
Меган Зоопарк Явсан Нь
Меганы Явган Аялал
Меган ба W. I. Тогоочийн Тэмцээн
Меганы Жолоодлого
Меган Дарвуулт Онгоц Дээр
Меган Карнивал Дээр
Меган Зул Сарын Баяр Дээр
ӨГҮҮЛЭХИЙН УЧИР

Тус хэвлэлийг чадах чинээгээрээ миний амьдралд тусалдаг,
үүгээрээ ах дүү бид нарыг өсгөж хүмүүжүүлсэн эцэг эх Колин болон
Марион нарыг минь баярлуулж байдаг хайрт гэргий Праном Жонсод
зориулж байна. Буян нь дэлгэрэг.

ТАЛАРХАЛ

Шаргуу хөдөлмөрч эхнэр Праном болон хавтасны зураг загварыг
хийхэд тусалсан найз Лорд Дэвид Проссерт талархалаа илэрхийлье.

УРМЫН ИШЛЭЛҮҮД

“Сонссон зүйл болгондоо шууд бүү итгэ,
Хүний хэлсэн болгонд, цуурхал бүрт нягтлалгүйгээр шууд бүү итгэ,
Та шашны ном судраасаа уншсан болгондоо нягтлалгүйгээр шууд
бүү итгэ,
Ахмадууд, багш нарын эрх мэдэлд нягтлалгүйгээр шууд бүү итгэ,
Үеэс үед дамжин ирсэн уламжлалд нягтлалгүйгээр шууд бүү итгэ,
Гэвч ажиглалт шинжилгээ хийсний дараа, аливаа зүйл үндэслэлтэй
нийцэж, хэн нэгэн болоод бүгдэд сайн сайхнаар нөлөөлж байвал
түүнийг хүлээн авч түүнд нийцүүлэн амьдар”

Гуатама Будда

Дуу хоолой нь салхинд гардаг Агуу Сүнс, намайг сонс. Намайг хүч
чадал эрдэм мэдлэгээр өсгөөч.

Улаан ягаан нар жаргах бэлгийн нүдийг хайрлаач. Таны өгсөн зүйлсийг миний гар хүндэтгэн авах болтугай.

Олон зууны тэртээх хүмүүст зааж сургасан шиг навч, чулуу болгоны доор нуугдсан нууцуудыг надад зааж өгөөч.

Хамгийн том дайсан болох өөртэйгээ тулалдахын тулд (ахынхаас их биш) өөрийн хүчээ ашиглая .

Дэлхий дээрх амьдрал минь нар жаргахтай адил алга болоход миний Сүнс ичгүүргүйгээр танд эргэж очихын тулд би үргэлж чиний өмнө цэвэр гар, нээлттэй сэтгэлээр үг хэлэхийг зөвшөөрөөч..

(**Sioux**-ийн уламжлалт залбиралд үндэслэсэн)

Table of Contents

Оуэн Жонс

1 ХОБСОНЫ СОНГОЛТ

2 УХААРАЛ (СЭРЭМЖ)

3 ЭЭЖИЙН БЯЦХАН ТУСЛАГЧ

4 УРАМ ЗОРИГ

5 ХӨРШҮҮД

6 МЕГАНЫ НАЙЗУУД

ХОРИГЛОЛТ

1 ХОБСОНЫ СОНГОЛТ

Меган дахиад л нулимс бүлтэлзүүлэн нүүрсний зооринд түгжигдэв. Тэр дөнгөж арван хоёрхон настай, ээж нь яагаад түүнд ийм аймар зүйл хийж байгааг тэр ойлгохгүй байв. Өмнө нь тав зургаан удаа ингэж зооринд түгжигдэж байсан ч түүний аав энэ талаар юу ч мэдээгүй гэж тэр боджээ. Тэр аавдаа хэзээ ч энэ талаар хэлж байгаагүй бөгөөд түүний ээж ч энэ талаар хэлэхгүй гэдэгт итгэлтэй байв.

Меган ээжтэйгээ бие биенээ доош хийхгүй байх аман бус тохиролцоотой байгаа ч тэр дахиад л, бохир тоостой орчинд хэний ч мэдэхгүй аймшигт амьтадтай зооринд хоригдож байна.

Тэр өөрөө ч мэдсэнгүй. Түнэр харанхуйн дунд ээжээсээ гаргаж өгөөч гэж уйлж гуйх чадалгүй болов. Урьд нь тэгэж гуйдаг байсан боловч түүний ээж суллагдах болзол гэж үндэслэлгүй шаардлага тавьдаг байжээ. Түүний мэдэх шаардлагууд нь охин биелүүлж чадахааргүй, оролдлого хийж үзэхэд ч маш хүнд шаардлагууд юм.

Заримдаа, тохиролцоог анхаарч үздэг цор ганц хүн нь өөрөө юм шиг санагддаг байв.

Өөрөө ч мэдэлгүй, түүний нулимс дахин хацрыг нь даган урсаж, түүний нүүрэн дээрх тоосон дээгүүр үл мэдэгдэм зураас татуулан, нүүрсний тоосыг урсган сурагчийн форм дээр нь унагав. Тэр үнэхээр их уйлав. Түүнийг маш сайн ойлгодог ээж нь ганц охиндоо яаж ингэж бүдүүлэг хандана вэ?

Ээж нь зоорины хаалганы хажуугаар өнгөрөхдөө хаалгыг нь тоос сорогчоор албаар цохиход Меган өөрийн эрхгүй үсрэв. Тайтгар төрүүлэх сүүмэлзсэн гэгээ ч байхгүй, тэгээд ч тэр өөртөө хамгийн их тус болох зүйлийг хийж нүүрсний овоолог өөд зүтгэж хана хүрээд дараа нь баруун талруугаа зүтгэж буланд хүрэв.

Тэр хувцсаа хөлд тээг болгохгүйн тулд урт дашинзаараа хөлөө ороон хумиж тогтоов. Тэр цамцныхаа бүх товчийг товчлоод, оймсоо татаж, свитер цамцаа толгойдоо углаж, гараа ханцуйдаа хийв. Ингэснээр Меган нүүрсний зооринд байх амьтдаас аюулгүй болгоно гэж мэдэж байв. Тэр сүнс, хий үзэгдэл зэрэг зүйлээс айгаагүй боловч хамгийн асуудалтай нь түүн дээгүүр шавж гүйж, түүнийг хазан цусыг нь сорж байна гэж бодохоос тэвчихийн аргагүй болов. Тэр бас аалзнуудыг үзэн яддаг боловч сургуулийн дүрэмт хувцсаараа ороон

хамгаалсан ч оймсных нь дээгүүр хэдхэн инчийн зай ил гарсанг мэдэж байв. Тэр үхэрнүүдээ өөрийн гуяндаа сайн шахаж тэвэрсэн тул ойролцоолвол хэдхэн инчийн зай л ил гарсан байлаа.

Тэр уйлахаа больё доо гэж бодов. Хэсэг хугацаанд ч гэсэн тэр эцэст нь суллагдах болно, хүлээнэ гэдгээ мэдэж байлаа. Хэзээ ийм зүйл болох вэ гэвэл – ойролцоогоор 5 цаг 30 минутын үед, түүнийг цэвэрхэн болгож амжихаар, аавыг нь ажлаасаа ирэхээс цаг хагасын өмнө болно.

Меган яагаад ээж нь ийм зүйл хийж байгааг ойлгож байв. Учир нь Меган биш ээж нь өөрөө айж байв. Түүний ээж охиноо сүрдүүлж, хүссэнээрээ түүнийг айлгах санаатай байв. Асуудал нь Меган сүрдээгүй бөгөөд сүрдэх юм байгаагүйгээс болжээ. Тэр олон зуун удаа ээждээ тайлбарласан боловч тэрээр түүнийг шууд одоогийн байдалд оруулж дуугүй болгожээ.

Түүний эцэг эх хоёул Католик шашинтай, ээж нь хэт Католик сүсэгтэй бөгөөд аав нь арай тийм биш. Ээж нь Хойд насны амьдралаас эмээдэг, ээж нь хэлэхдээ зөвхөн өөрийнхөө төлөө биш, тэр өөрөө сайн Католик шашинтай хүн гэж үздэг, үүргээ сайн гүйцэтгэсээр байвал Диваажин дэх байр сууриа аль хэдийн баталгаатай болгоно гэдэгтэй итгэлтэй байна гэжээ. Меганы хувьд асуудал бол ээж нь гүйцэтгэх үүргийнхээ нэг хэсэг нь охиноо нүүрсний зооринд түгжих явдал гэж бодсонд байгаа юм. Тийм учраас тэр тэнд байна.

Түүний аав бас Католик болж төрсөн боловч ээж шиг нь хэт шүтлэгтэй биш. Хэрэв хүмүүс мөнхийн ял шийтгэл хүлээхийг хүсвэл энэ нь зөвхөн тухайн хүний хэрэг гэж тэр үздэг байв. Тэрээр өөрийнхөө болон хайртай хүмүүсийнхээ төлөө санаа тавьдаг байсан ч бяцхан охидын хувьд ч гэсэн чөлөөт сонголт байгаа гэдэгт итгэдэг байв.

Тэр жоохон ч гэлээ, ээж нь түүнийг хамгийн их анхаардаг гэдгийг ойлгосон учраас Меган хэдий ээж нь түүнд юу хийдэг байсныг үл харгалзан аав ээж хоёртоо хоёуланд нь хайртай. Меган хоёуланг нь адил хайрлахыг хичээсэн боловч Меганы бодлоор асуудал нь түүний ээжид сайн Багш байгаагүй эсвэл ээж нь өөрийн нүд, чих, мэдрэхүйдээ итгэхээс айдагт байдаг юм.

Сайн багш нар ямар байдгийг тэр баттай мэдэхгүй, гэхдээ түүнд болон бусад хүмүүс сайн багштай гэдгийг тэр мэдэж байсан боловч ээж нь тэднийг хүлээн зөвшөөрдөггүй тул ээж нь бусад хүмүүс сайн

багштай гэдэгт итгэхийг хүсдэггүй байв. “Эцсийн эцэст” ээж нь түүнд “Би гучин дөрөвтэй, чи дөнгөж арван хоёртой. Би Католик шашны сургуульд сурч байсан бол чи зөвхөн нийтлэг шашины цогцолбор сургуульд сурдаг” гэж хэлжээ.

Түүний ээж ерөнхий боловсролын сургуульдаа ямар нэгэн асуудалгүй байсан бололтой, гэхдээ тэр “interdenominational-нийтлэг шашин” гэдэг үгийг шүлстэйгээ хаячихжээ. Меган энэ асуудлыг хэзээ ч ойлгож байгаагүй. Тэрээр ихэнх шашнаас сайн-муу, ухаалаг-тийм ч ухаалаг биш, ухамсартай-тийм ч ухамсартай биш зүйлстэй тулгарч байсан.

Түүний ээж үнэнч сэтгэлтэй, ухаалаг, өндөр ухамсартай ангилалд багтжээ.

Түүний аав сайн, ухаалаг, сайн ухамсартай болов.

Меган өөрийгөө сайн, боломжийн ухаалаг, маш ухамсартай гэж дүгнэжээ.

Энэ бол түүний асуудал юм. Тийм ч учраас эр нүүрсний тас харанхуй нүхэнд одоо ч дээгүүр нь гүйж байж магадгүй амьтадтай хамт түгжигдсэн юм. Тэр бодлоосоо болж дагжсан боловч, аандаа ийм болно гэдгийг мэдсэн шиг одоо уйлахаа болив.

Түүнд хоёр сонголт байгааг мэдэв.

Тэр аавынх нь хойгуур өөрт нь юу тохиолдоод байгааг ар араас нь хэлж, хэрүүл маргаан үүсгэж, улмаар гэр бүл салгаж асрамжинд очиж магадгүй юм шиг эсвэл хэлсэн шиг нь мэдээгүй юм шиг дүр үзүүлэх байлаа.

Меган зооринд түгжигдэхдээ хамгийн сайн хийж сурсан зүйл бол өөр зүйлийн талаар бодох юм. Хамгийн их бодох дуртай зүйл бол түүний найзууд гэдгийг мэджээ. Тэр олон найзтай байсангүй, гэхдээ тэд түүнд онцгой байсан юм. Түүний хайртай найзууд нь түүний өвөө Вачининша болон түүний тэжээвэр муур байв.

Тэр нүдээ анин тайвшрахыг хичээгээд тэд урд нь зогсож байгаа эсвэл хажууд нь сууж байгаагаар дүрслэхийг хичээв. Энэ нь түүнд үргэлж дулаахан мэдрэмж төрүүлдэг байсан тул тэр сэтгэлээр унах үедээ үүнийг хийдэг байв. Энэ бол амьдрал шударга бус мэт санагдах үед түүнийг даван туулах түүний бяцхан заль мэхний нэг байв.

Меган гуяныхаа араар ямар нэгэн зүйл дээш цамнаж байгааг мэдрэх шиг болж, цамцныхаа доороос намуухан чимээг сонслоо.

Тэр хэсэг зуур хөшиж орхив.

2 УХААРАЛ (СЭРЭМЖ)

Энэ бүхэн түүнийг дөнгөж хөлд орж байх үеэс эхэлсэн юм. Эцэг эх нь хоёулаа ажилладаг байсан тул өдөр нь (ээжийн ээж) эмээ дээрээ үлддэг байв. Ээжийнх нь эцэг эх нь уламжлалт зан заншилтай байсан бөгөөд нөхөр нь ажилдаа явж, эхнэр нь гэртээ үлдэж гэр орны ажил хийдэг, хүүхдүүд нь тусдаа гараад гэрээсээ явсан айл байв. Хатагтай Уайт хэзээ ч өөрийн найз нөхөдтэй байгаагүй. Түүний таньдаг хүмүүс нөхрийнх нь найз эсвэл нөхрийх нь найзын эхнэр байсан тул хатагтай Уайт өөд болохдоо огт найзгүй байсан.

Хатагтай Уайт хэд хэдэн удаа өөрийгөө уйтгар, ганцаардлаас болж галзуурч байна гэж бодож байжээ.

Меганыг өдөр, хааяа шөнө харж хандах нь бурхны бэлэг байлаа. Хатагтай Уайт үүний ачаар уйтгараас болж галзуурах шахахаа больсон гэж олон хүнд хэлэхийг хүсч байсан боловч хэдэн жилийн дараа Меган үйл явц эхлэхээс нь өмнө эртхэн ирдэг байж дээ гэж олонтаа боддог байв.

Меганыг нялх байхад нь ямар нэг зүйл буруу болсныг харуулсан анхны шинж тэмдэг байв. Меган тоглоом, эд зүйлээ зүүн гараараа түүж эхэлсэн нь хатагтай Уайтад маш муу тэмдэг байв. Эхлээд хатагтай Уайт эд зүйлийг зүгээр л Меганы баруун гарт шилжүүлж өгөөд “Зүүн гар бол муу, баруун гар нь сайн” гэж хэлдэг байсан боловч хэдэн долоо хоногийн дараа Меган зөв арга барилаа сураагүй хэвээр байсанд зүүн гарыг нь зөөлөн алгадсан нь зүүн гар нь муу гэсэн үг байв.

Өдий насны бүх хүүхэд сурах байсантай адил, хатуу чанга Павловын сургалтанд хамрагдсаны дараа Меган баруун гараа ашиглаж сурав. Түүний эмээ Меганы сургалт хэрхэн үр дүнтэй байгаад маш их баяртай байсан тул нэг өдөр тэр сайн мэдээг охиндоо анзаараагүй байхад нь ялгуухнаар мэдэгдэв, Меган зүүн гараа хэрэглэх дуртай байсан бол одоо зөвхөн баруун гараараа юм авч явдаг болжээ.

Меганы ээж Сюзан энэ талаар юу ч бодоогүй байв. Тэрээр ээжид нь ‘сонин хачин арга’ байдгийг мэдэж, түүнд зөвшөөрөв. Гэсэн хэдий ч түүний санаж чадаагүй зүйл бол ээж нь түүн дээр туршсан байх ёстой байсан бөгөөд хэрэв тийм биш байсан бол тэр өөр хүн байх байлаа. Эхлээд тэр солгой байх ёстой байв.

Сюзан өөрийн нөхөр Робертод Меган төрөлхийн зүүн гараа ашиглах хандлагатай байсан гэж хэлээгүй, харин түүнийг “зодсон” тул, аав нь өөрөө солгой гартай, ийм хуучин мухар сүсэгт тэвчээртэй ханддаг тул үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байв. Хатагтай Уайт Робертийг үл зөвшөөрсөн нэг шалтгаан нь тэр солгой байсан боловч түүнийг болон түүний сүнснийг аврахад аль хэдийн оройтсон гэж үзжээ.

Түүнийг Сюзанд дурлаж, эцэст нь Роберттэй гэрлэх хүртэл бүгдийг хэцүү болгохын тулд бүх чадлаараа хичээсэн байна. Түүнийг үглэж, гадагш гарахыг нь хориглож, халаасны мөнгө өгөхгүй байж, шатны доорх шүүрний шүүгээнд түгждэг байжээ.

“Миний охион, чамайг ийм зан гаргана гэдэгт би итгэхгүй байна” гээд хажуугаар өнгөрөхдөө шүүгээний хаалгыг цохин хашгирдаг байжээ. “Эмнэлэгт солигдсон байх гэж бодож байна. Би чам шиг охинтой болохооргүй байсан” гэж хэлжээ.

Сюзан азтай байж. Тэдний байшинд нүүрсний нүх биш нүүрсний бункер байсан ч, хатагтай Уайт охиндоо тэнд “буг чөтгөр” байгаа байх гэж хэлсэн учир тэр шүүрний шүүгээг адилхан аймшигтай газар гэж тэр бүр өсвөр насандаа олж мэдсэн бөгөөд Меганы дургүй байх ижил шалтгаанаар болон бусад зүйлсээс болж хоригддог байв. Тэрээр ийм тохиолдолд Сюзаныг буланд чимээгүйхэн суугаад толгойгоо халхлахыг зөвлөсөн бөгөөд ингэсээр ‘буг чөтгөрүүд түүнийг анзаарахгүй байх’ гэжээ.

Меганыг ярьж сурсны дараа хатагтай Уайт үүнийг хувийн амжилт гэж ойлгов. Тэрбээр Сюзан, Роберт нарт энэ талаар огтхон ч гавьяа өгөөгүй бөгөөд “орчин үеийн эцэг эхчүүд”

хүүхдүүдээ цаг зав гаргадаггүй, хэрэв өвөө, эмээ нар нь байгаагүй бол дараагийн үе нь “бүрэн тэнэг” болно гэж найз нартаа хэлж байжээ.

Хатагтай Уайтийн ихэнх танилууд түүнийг ямар хүн болохыг мэддэг байсан бөгөөд зүгээр л зөвшөөрсөн шинжтэй толгой дохиж, ярианы сэдвийг өөрчлөн эсвэл боломж байвал яаран явдаг байв. Яриа нь ихэвчлэн дараахь байдлаар өрнөдөг байв.

“Аа, хатагтай Уайт, та бяцхан Меганыг харж охиндоо туслах гайхалтай ажил хийж байгаа гэдэгт би итгэлтэй байна ... Энэ жил хайтан цэцгүүд нь ямар байна вэ?”

Ноён Уайт өөрийн төсөөллийг хязгаарлахын тулд Дэлхий дээр байхаа больсон тул бяцхан Меганыг эмээгийнх нь аашинд орхисон боловч энэ нь огт үнэн биш байсан. Хатагтай Уайтын хөлний урд шалан дээр сууж байхдаа Меган заримдаа тоглоомоо гаргаад ‘Өвөө’ -дөө өгдөг байв.

Эхлээд хатагтай Уайт хүүхдийг будилж байна гэж боддог байв. Тэрээр ‘бусад өвөө эмээ нар’ түүний бяцхан туслагчийг будилуулдаг гэж таамаглаж байснаар буюу өмнө нь мэдэж байсан туршлагаараа, Меган тоглоомоо өргөн ‘Өвөө’ гэж хэлэхэд эмээ нь аваад “Эмээ” гэж хэлж байв. Дараа нь цөхрөнгөө барж, ‘Эмээ, Меган, Өвөө биш!’ гээд түүний хөлийг нь зөөлөн алгадав.

Гэсэн хэдий ч Меган түүнийг “Өвөө” биш харин “Эмээ” гэж дуудах нь түүнд ямар ч аргаар хамаагүй баруун гараа ашиглахаас илүү хэцүү байв. Меган мөн “муужгай” гэж дуудсан бөгөөд агаарыг илбэж, хөхрөх нь илт харагдаж байв.

Меган “муужгай” “Гррр” гэж дуудаж эхлэхэд хатагтай Уайт хүүхдийн хэт их төсөөллийг буруутгаж байсан боловч ‘өвөө’ гэсэн үгс түүнийг зовоосоор байв. Нэг өдөр тэр Сюзанаас Меган Робертын эцэг эхийг хэн гэж дууддагийг асуув.

“Өө, Меган үнэхээр эгдүүтэй. Тэрбээр эмээ, өвөө нарт зориулсан Уэльсийн үгсээр ‘Наин ба Тэйд’ гэж дууддаг. Тэд биднийг түүнийг Уэльсийн сургуулийн насанд хүрэхэд нь тэдэнд өгөхийг хүсч байгаа ч Роберт бид хоёр одоогоор итгэлгүй байна. Ээжээ та юу гэж бодож байна?” гэж асуув.

Хатагтай Уайт Меганыг Католик шашны сургуульд сурна гэж найдаж байсан боловч Зүүн Гарт Роберт хүүхдүүд шашин шүтлэгтэй байх ёстой гэж итгэдэггүй тул ийм боломж бага байгааг мэдэж байсан. Бах! Тэр юу мэддэг юм бэ? Зүүн гарт хүн энэ талаар юу мэдэх вэ? гэж боджээ.

Гэхдээ тэр “Хонгор минь, Меганыг явуулахдаа маш болгоомжтой байгаарай. Түүнийг хүндэтгэл заадаггүй эсвэл хуучны сайн сахилга батыг сахидаггүй солгой хүмүүс багшилдаг, орчин үеийн хатуу ширүүн аль ч сургуульд оруулахыг битгий хүсээрэй, үгүй бол Меган Дунд Боловсролын Ерөнхий Гэрчилгээний шалгалт хүртлээ гэртээ байж магадгүй юм” гэжээ. Тэрээр “зүүн гар”, “хүндэтгэл”, “сахилга баг” гэсэн түлхүүр үгсээр Сюзаныг өөртөө татна гэж найдаж байсан ч Робертын тэнэг солгой санаанд охиноо алдчихвий гэж айжээ.

Түүний хийж чадах бүх зүйл бол Меганы ялзрал/цадиггүй байдлыг зогсоох байв. Роберт болон түүний охины ядуу, ялдам байдлыг үгүй хийж мэдрэмтгий болгох ялзрал/цадиггүй байдал. Түүнийг шатан дор

түгжихийг оролдох санаа байсан боловч Роберт хэзээ нэгэн цагт мэдвэл Мегантай байхыг сүүлчийн удаа зөвшөөрч, дараа нь хоёулаа үүнээс ч дор болно гэдгийг мэдэж байв. .

Гэхдээ хатагтай Уайт дотроо муудалцаж үүнээс дор байдалд хүрвэл асрамжийн газрын гадаа очиж үхэхээс өөр замгүй болно гэдгийг сайн мэдэж байв.

3 ЭЭЖИЙН БЯЦХАН ТУСЛАГЧ

Меган таван настай байхдаа яслид явдаг байхдаа эмээгээ бараг хараагүй байв. Энэ нь Меганд сайнаар нөлөөлсөн гэж олон хүн хэлсэн боловч эмээгийнх нь хувьд тийм ч баяртай байсангүй.

Тэрээр зургаан сарын дараа солиорч нас баржээ.

Эмч нар хатагтай Уайт яагаад нас барсныг мэдэхгүй байсан боловч ерөнхийдөө түүнийг ганцаардмал байдлаас болж нас барсан гэж үзэв.

Мэдээжийн хэрэг Меган эмээ нь “таалал төгссөн” гэдгийг л мэддэг байсан ч энэ нь түүнд тийм ч их ач холбогдолгүй байв. Тэр “залуу” байсандаа ч биш, тоохгүй байгаадаа ч биш. Уг үйл явдал зүгээр л Меганы амьдардаг ертөнцийн тухай ойлголтын нэг биш байв.

Меганы ертөнц бол ихэнх хүмүүсийн ойлгодог ертөнц биш гэж хэлэх нь зөв байх. Меган зургаан жилийн турш хүмүүс үхсэн гэдэгт хэзээ ч итгэж байгаагүй. Мэдээж- тэрээр бие нь үхсэн гэдгийг мэдэж байсан. Түүний муур, түүний тоть үхэж, гэр бүлийнхэн нь хайрцганд хийн цэцэрлэгт булчихсан байсан ч тэр үед тэр эцэг эх нь түүний ашиг тусын тулд жүжиглэж байгаа юм шиг санагджээ.

Тэр үед ч гэсэн эцэг эх нь үхэл, амьдралын талаар ямар ч ойлголтгүй байсан гэдгийг тэр мэддэг байсан, учир нь Меганд бодит ялгаа байдаггүй байв. Тиймээ, тэр бүх гэрийн тэжээвэр амьтдыг үхсэний дараа хараагүй нь үнэн байв. Тэр Лоппи Луге туулайг, эсвэл түүний канари Голдие бялзуухайгаа үзээгүй ч Бекки хөгшин нохойгоо унтаж сэрээд байхдаа олон удаа харж байжээ. Меганы унтаж байгт эсвэл сэрүүн байгаа нь бодит ялгаагүй байв.

Энэ нь түүний анхны загинуулах болсон гэдгийг ээждээ хэлэв.

Меган хүүхдүүдийн л адил хүн бүрийг өөртэйгөө адилхан сэтгэдэг гэж угаас бодов. Түүнийг ‘ийм утгагүй зүйл ярих ёсгүй жоохон охин’ гэж хэлнэ гэж бодоогүй байжээ.

Энэ бол зөвхөн түүний л асуудал байв.

Тэр харсан зүйлээ “утгагүй зүйл” гэж боддоггүй байв. Тэр өвөөтэйгээ олон жил ярьсангүй юу? Түүний эмээ, ээж нь түүнийг харж чадахгүй байгаа нь түүний буруу биш бололтой.

Өнөөгийн сөргөлдөөн ба Меганий сүүлийн үеийн асуудлуудын ихэнх нь арван нэгэн настай байхад, Бямба гарагийн өглөө хаалга тогшноор эхэлсэн юм.

“Би үүнийг авна, Ээж,” гэж өөрийн дураар оролцож эхлэв.

Энэ бол зүгээр л өдөр бүр явдаг явуулын сойз худалдагч байв. Сюзан охиноо гарахад нь туслахаар цайны алчуур дээр гараа хатаагаад коридороор яаран гарч ирэв.

“Хэн бэ, хонгор минь?”

“Өө, сойз зардаг хүн ...” гэж тэр болгоомжтой хариулав.

Таван минут орчим ярилцсаны дараа Меганы ээж нь сойз зардаг эрийг барааг нь үзэхээр урьсан юм.

“Ээж! Түүнийг битгий оруулаарай!”

Ээж нь “Бүү тэнэгт, охин минь” гээд. “Юу болов?” гэж асуув

“Гэхдээ, Ээж”, “Та түүний өнгө гэрлийг нь харвал маш муу хүн болохыг та харж болно.” гэж Меган хэлэв.

‘Луиварчин’ гэсэн хэллэг Меганы үгсийн санд одоог хүртэл тодорхойгүй байв. Явуулын худалдагчийг зочны өрөөнд орох нарийхан хонгилоор нэвтрэн ороход ээж нь түүнийг хажуу тийш нь түлхэв.

“Ийшээ явна уу” гэж ээж нь хэлээд, “Би охиныхоо өмнөөс уучлалт гуйж байна, гэхдээ хүүхдүүд ямар байдгийг та мэднэ шүү дээ ... Тэд

хамгийн хачин зүйлс хийдэг шүү дээ? Ноётоон та хүүхэдтэй юу? ”Гэж асуув.

Энэ үед Меган шатан дээр гулсаж байв. Түүний зөвлөгөөг үл тоомсорлож байсан анхны тохиолдол биш бөгөөд байшинг гаднаас нь харахад хоосон юм шиг байхад үр дагавар нь юу болохыг мэднэ гэж боджээ.

Сойзны худалдаачин гарч хаалга хаагдахад Меган ээжийнхээ түүн рүү хашгирахыг сонсов.

“Меган, хурдан буугаад энд хүрээд ир! Чи намайг сонсож байна уу?”

Тэр орноосоо гулсаж, шаахай углаад гал тогоонд байсан ээж рүүгээ аажуухан буув.

“Чи яагаад намайг ингэж ичгэвтэр байдалд оруулаад байгаа юм бэ?”

“Би түүний эргэн тойрон дахь өнгө гэрлүүдийг харсан, аймшигтай хар байсан бөгөөд аяг угаалтуурын бохир ус хоолой руу эргэлддэг шиг хуйларч байсан ...”

“Ийм утгагүй зүйлийг дахиж битгий эхлээрэй. Хэрэв би чамд нэг удаа хэлсэн бол мянга дахин хэлсэн шүү, хүмүүсийн эргэн тойронд өнгөт гэрэл байхгүй. Хүмүүсийг тойрон эргэлдэж буй өнгөт гэрлийн талаар ярьдаг, миний амьдралын туршид таних цорын ганц хүн бол чи юм. Намайг ойлгож байна уу? Чи үүнийгээ хурдан боль эсвэл юу болохыг чи өөрөө мэдэж байгаа шүү ...”

“Тийм ээ, Ээж, гэхдээ тэр муу хүн байсан ... Би мэдэж байна. Тэр зөвхөн сойз зардаг хүн хэдий ч гэрт орж ирсэн, орж ирээд таныг эргэн тойрон юутай байгааг харсан...”

“Чи дуугүй байх уу! Чи гэм зэмгүй хүмүүсийг муу зүйлд буруутгах эрхгүй. Чи тэр хүний талаар өчүүхэн ч зүйлийг мэдэхгүй. Би тэнэг биш, Хүнтэй нэг уулзахдаа муу хүнийг таньдаг, тэр эелдэг, сайхан залуу байсан. Хэрэв би түүнд ямар нэгэн асуудал байна гэж бодож байсан бол би түүнийг гэртээ оруулна гэж бодож байна уу? Үгүй үү? Чи ээжийгээ ийм тэнэг гэж бодож байна уу?” гэж асуув.

Меган доош харан тонгойж шаахайгаа ширтэн хээг нь ажиглан зогсов. Тэр толгойгоо сэгсрээд “Үгүй ээ, Ээж, гэхдээ би зөвхөн туслая л гэж бодсон юм” гэж хэлэв.

“За яахав, нэг удаадаа. Хэрэв чи туслахыг хүсвэл өөр аргаар туслаж болно. Намайг олны өмнө ичээх нь тус болохгүй. Одоо гадаа гарч тогло. Би чиний аавын цайг бэлдэх ёстой, эс бөгөөс түүнийг ирэхэд чи гадаа гарч тоглож чадахгүй болох байх. Алив, яв, яв, цаашид хүмүүсийн эргэн тойрон дахь өнгөт гэрлийн тухай сонсмооргүй байна. Чи намайг сонсож байна уу?” Гэж асуув

“Тийм ээ, ээж.”

Тэр гадаа гарч, цэцэрлэгт байх аавынхаа хийсэн савлуур дээр суулаа. Хэдэн инчийн зайд аажуухан нааш цааш савлаад тэр худалдаачин болон өнгөт гэрлүүдийн тухай бодож байв.

Өмнө нь бусад хүүхдүүдтэй энэ талаар ярьж байсан тул бусад хүмүүс бас өнгөт гэрлийг харж чаддаг гэдгийг тэр мэдэж байв. Түүний найзуудын нэг, хоёр нь гэрлийг харж чаддаг байсан ч ихэнх нь харж чаддаггүй байв. Тэр бүх найзуудаасаа өнгөт гэрлийг хамгийн тод харж чаддаг юм шиг санагдав. Найзуудынх нь зарим нь зөвхөн бүдэг гэрлийг харах боломжтой байсан бол Меган гэрлийг байнга тод хардаг байсан бөгөөд гэрлийг харахаа болих гэж зовдог байв.

Тэдгээр өнгө гэрэл юу гэсэн үг болохыг тэр сайн мэддэггүй байсан ч цөөн хэдэн зүйлийг сурч мэдсэн байв. Эхлээд харанхуй өнгөнүүдээс тод өнгө нь илүү дээр юм шиг санагдсан. Тод шар, алт, жүрж нь аз жаргал, илэн далангүй гэсэн утгатай юм шиг санагдсан - тэр хүн чамайг хараад баярлаж, танд ямар ч хор хөнөөл хүсээгүй мэт. Харанхуй, шаварлаг, хүрэн эсвэл саарал өнгө нь аз жаргалгүй, уур уцаартай, аймшигтай хүмүүсийг хэлмээр санагдсан; эсвэл заримдаа зүгээр л ааш муутай хүмүүс, яг л одоо ээжийнх нь байж байгаа шиг.

Өнгө эргэлдэж байгаа нь хэн нэгэн бодож байгаа гэсэн үг байх... Магадгүй тэр бодож байсан байх, гэхдээ тэр үүнд хараахан итгэлтэй байгаагүй юм. Эргэлдэх тод өнгө нь сайн зүйл бодож байна, эргэлдэх харанхуй өнгийг муу зүйл боддог гэсэн үг юм. Энэ нь түүний худалдагчийн эргэн тойронд харсан зүйл байв.

Бүх гэрлүүд ямар утга илэрхийлж байгааг зуун хувь мэдэхгүй байгаа тул түүний ээж нь худалдаагчныг муу санаагаар шууд буруутгах ёсгүй гэж зөв хэлсэн байж магадгүй юм..

Хэн нэгэн өөрөө унаж бэртэж, гэмтээсэн үед тэр газар нь арьсан дээр хөхөрдөг шиг харанхуйлж байгааг тэр анзаарсан байв. Тэрээр хажуу айлын эмгэнийх шиг 'цус хурж хөхөрсөн өнгө'-ийн гэрлийг хүмүүсийн заримаас олж харжээ. Тэр эмгэн цээжнийхээ зүүн хэсэгт хөх, хүрэн бор толботой байсан боловч Меган түүнээс асуухад бие нь сайн байгаа гэж хариулсан.

Чухамдаа Меган бие нь сайн байгаа эсэхийг мэдэхийн тулд хэд хэдэн өдөр гүйн очиж асуусан боловч тэр сайн байгаа гэж хэлсэн. Меган өвдөж байгаагаа мэдэхгүй залуу өвчин үү гэж гайхав. Түүний сонсож байсан хорт хавдрын аль нэг нь угжирахад хэдэн жил шаардагдах байх.

Математик сурахаас хамаагүй илүү ашигтай тул өнгөт гэрлүүдийн ангиуд байх ёстой гэсэн бодол Меганы толгойд эргэлдэн орж ирэв. Меган математикийг үзэн ядаж, өсөж том болохоороо хэзээ ч математикаар юм хийдэг ажилд орохгүй гэж шийджээ.

Тэр өөртөө чанга чанга инээгээд байсан ч ээж нь түүнийг гал тогооны өрөөний угаалтуурын цонхоор харж охиныхоо толгой зүгээр байгаа гэж гайхав. Заримдаа ч тэр Меган бидний охин мөн үү гэж хүртэл боддог байв. Энэ бодол нь түүний толгойд хүчээр орох бүрт тэр өөрийгөө үзэн ядаж өөрийгөө хязгаарлаж хэвийн болдог байв.

Сюзан 'Розмаригийн нялх хүүхэд' гэж бодоод инээдтэй юм шиг санахыг хичээсэн боловч энэ санаа нь тийм сайхан, өөдрөг, сэргэлэн цовоо, тусч, хайраар дүүрэн хүүхдийн ээжийн нь хувьд муухай, жижиг бодолтой, аймшигтай, зохисгүй юм байна гэж бодлоо.

Меган зүгээр л хачин асуулт асууж, хачин зүйл ярьдаг хүүхэд байсан. Тэр нэг бүтэн улирал орчим нь бусад хүүхдүүдээс өөр байсан бөгөөд ээж нь ч, өөрөө ч үүнийг хэрхэн даван туулахаа мэдэхгүй байв. Тэр Робертээс зуун удаа асуусан боловч түүнийг анзаараагүй гэдэгт итгэлтэй байв.

Телевизээр түүний анхаарлыг татах сонирхолтой зүйл байхгүй үед тэр нэг удаа уг сэдвийг хөндөж ярилцав.

"Роберт..." гэж тэр яриа эхлэв, "Меган шөнө унтаж чадахгүй байна гэж хэлээд байна учир нь... зүгээрээ, Аавдаа хэл, хайраа. Роберт, сонс л доо. Алив Меган, аавдаа надад урьд өдөр юу хэлсэнээ хэлээрэй."

Меган аавынхаа өвөр дээр гарч, түүнийг тэвэрч энгэрээ наав.

"Энэ хүүхэд хэн бэ? Сургууль дээрээ асуудал гарсан уу?" гэж асуув.

Меган аавдаа хайртай. Ээждээ ч бас хайртай байсан боловч аав нь хэзээ ч түүнийг хэдэн зуун сая жилд нүүрсний зооринд цоожлохгүй гэдгийг мэдэж байв.

"Үгүй ээ, аав аа, сургууль дээр биш. Математикаас бусдаар би сургуульдаа дуртай... Би математикуыг үзэн яддаг. Ноён Женкинс үнэхээр уйтгартай. Үгүй аав, асуудал намайг орондоо орох үед болоод байна. Орондоо ороод, хөнжилдөө шурган, бүрэн нойрсохыг хичээдэг, тэгээд яг унтах гэж байтал хүмүүс надтай ярьж эхэлдэг, заримдаа тэд надтай ярьж бас заримдаа

хоорондоо ярилцдаг, гэхдээ тэд намайг сонсохыг хүсдэг. Би чагнасан юм биш шүү, ааваа, шударгаар хэлье” гэж хэлжээ.

Аавынхаа царай, гэрлийг илүү сайн ажиглахын тулд тэр бага зэрэг хойшлов, гэхдээ гэрлүүдийг харахад дэндүү ойр сүлэлдсэн байв. Гэсэн хэдий ч түүний сурч мэдсэн бас нэг зүйл байв: түүний гэрлүүд сайхан хүмүүстэй нэгдэхэд түүнд сайхан санагдаж, асуудалтай хүмүүстэй нэгдэхэд тэр тухгүйгэж эвгүйрхэн, айж ичиж байв. Энэ бол түүний хараахан ойлгож амжаагүй өөр нэг зүйл байсан, гэхдээ тэр аавынхаа энгэрт үргэлж сайхан санагдаж байсан нь түүнийг анх анзаарахад хүргэсэн юм.

“Чи хананы цаанаас Жеймсийг сонсож байна уу, хонгор минь? Тэд үргэлж хоорондоо зодолдож, хэрэлдэж байх юм. Тэд дахиад л асуудалтай болсон бололтой. Тийм ээ.”

“Үгүй ээ, ааваа, Жеймс биш шүү дээ, би тэдний дуу хоолойг мэднэ. Хөгшин хатагтай Жеймс таныг муурын сүүлэн дээр нь гишгэхэд гаргадаг шиг инээдтэй дуу хоолойтой.”

Ноён Жеймсийн хашгирсан хоолойг дууриаж байгаад аав нь инээлээ.

“Хүүхэд минь, чи тэгээд юу гэж бодож байна даа өөрийнхөө асуудлыг?”

“Өө, ааваа, энэ юу болохыг би мэднэ шүү. Энэ бол хүмүүс. Энэ бол уугуул Америкчууд, би тэднийг заримдаа бас хардаг, гэвч ихэнхдээ би зөвхөн тэднийг сонсож чаддаг.”

“Америк уугуул иргэд, тийм үү? За манай гудамжинд, би хэзээ ч ... Дараа нь яасан? Орон нутгийн уугуул америкчууд шөнө унтлагын өрөөнд миний бяцхан охинд юу гэж хэлдэг вэ? “

“Өө, тэд маш сайхан уугуул америкчууд шүү дээ. Америкийн хуучин ковбой кинон дээр зурагтаар гардаг шиг биш. Чухамдаа нэг нь надад тийм кинонуудыг хэзээ ч битгий үзээрэй, түүний болон түүний хүмүүсийн талаар худлаа зүйл гаргадаг гэж хэлсэн. Худлаа зүйл хийдэг хүмүүсийг тэр яг... тэнэг хүмүүс гэх зэргээр дуудаж байсан.”

“Мунхруулга уу? эсвэл Үнэхээр үү? Уугуул Америкчуудын тухай киног шүүмжилдэг хүн яг энд, манай гэрт орж ирлээ гэж үү. Хэн үүнийг таамаглах билээ дээ, гэхдээ хэн ч байсан чамд тэгж хэлсэн хүнтэй санал нийлж байна. Маш ухаалаг зөвлөгөө сонсогдож байна. Чиний Уугуул Америкчуудын Кино шүүмжлэгч найз хэн бэ?” гэж аав нь асуув.

“Түүний нэрийг Васининша (Wacinhinsha) буюу англиар Цагаан Өд гэдэг. Тэр бол Сиуу (Sioux) омгийнх. Би түүний нэрийг их удаан санадаг байсан бөгөөд би буруу дуудсан үед инээлддэг байсан. Би заримдаа андуурч дуудахдаа аймшигтай зүйлсээр дууддаг гэж хэлсэн... Би түүнийг ихэнхдээ хардаг. Тэр хөгжилтэй гэж Меган хариу хэлэв.

“Васин... Цагаан Өд чамтай юу яридаг юм бэ, Меган?”

“Бүх төрлийн зүйлс үнэхээр шүү, Ааваа. Заримдаа тэр надад эрт дээр үеийн амьдралынхаа тухай, заримдаа надад шувуу шиг нисэх тухай эсвэл янз бүрийн зүйлийн тухай өгүүлдэг. Бид зүгээр л ярилцдаг.”

“Тэр Цагаан Өд хэдэн настай вэ?”

“Өө, тэр нэлээд хөгшин, гэхдээ би хэдэн настайг нь мэдэхгүй байна. Мумми, хүмүүсээс хэдэн настай болохыг нь асуух нь бүдүүлэг хэрэг гэж надад хэлсэн, гэхдээ би түүнийг тавь эсвэл жар орчим настай байх гэж бодож байна ... Ааваа таньтай ойролцоо юм байна.”

“Маш их баярлалаа, Меган, би дөнгөж дөчин хоёр настай...”

“Магадгүй, тэгвэл Цагаан Өд ч бас дөчин хоёр настай байх.”

“Би танай энэ найзтай нэг орой уулзаж болно гэж бодож байна уу?”

Би мэдэхгүй байна. Васининшагаас хамаарна гэж бодож байна, гэхдээ яагаад тэгж болохгүй гэж. Хэрэв та үнэхээр хүсч байвал.”

“За үр минь, одоо явж болно ганцаараа тоглож бай, би энэ тухай бодож, ээжтэй нь ярина. Васиний талаар надад хэлсэнд баярлалаа... Цагаан өд. Тэр маш сонирхолтой хүн бололтой. Бүү мартаарай, боломжтой үедээ ээждээ туслаж байгаарай, тэгвэл сайн охин болно шүү” гэж Меганд аав нь хэлжээ.

“Ааваа, би Ээжд туслахыг хичээдэг.”

“Би чамайг мэднээ охин минь, чи бол сайн охин шүү дээ? Чи бол ээжийн бяцхан туслагч” гэж аав нь хэлэв.

Робертод ойлгогдсон бүх зүйл бол Меган идэвхтэй, ургуулан боддог төсөөлөлтэй хүүхэд гэж хэлээд дараачийн амралтын өдрүүдээр Меганы өрөөг хуарагнан буудаллаж, толгодын оройгоос тэгш тал руу морь унасан Уугуул Америкчуудыг харуулсан ханын цаасаар тохижуулав.

“Тэнд,” гэж тэр Сюзанд хэлээд. “Меган уугуул америкчуудыг дахин дурдвал энэ бол зүгээр хардаг зураг. Тэнд бодит хэн ч байхгүй гэж түүнд хэлээрэй.”

Робертын санаа зовж байсан асуудал үүгээр төгсгөл болжээ. Асуудлыг шийдсэн; “Гэхдээ дараа нь Меганы өдөржингөө хэлсэн хийсэн ичгүүртэй зүйлсийг аав нь байнга бодох шаардлагагүй биз дээ?” гэж Сюзан бодлоо.

You've Just Finished your Free Sample

Enjoyed the preview?

Buy: <http://www.ebooks2go.com>